



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№72 /516/

2023.05.03

Цаг үе, үйл явдал

## ҮНДЭСНИЙ БИЧГЭЭРЭЭ ӨРСӨЛДӨЖ БАЙНА



Монгол Улсын Ерөнхийлөгч 2003 онд жил бүрийн 5 дугаар сарын энхийн Ням гарагийг Монголын үндэсний бичиг үсгийн баярын өдөр болгон зарлиг гаргасан. Эл өдрийг тохиолдуулан Батлан хамгаалах яамнаас харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын алба хаагч, ажилтан албан хаагчдын дунд Монгол бичгийн уралдааныг уламжлал болгон зохион байгуулдаг билээ.

Монгол үндэстний утга соёлын нандин өв болсон Монгол бичгийг хойч үедээ өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурч эзэмших сонирхлыг дэмжих, Монгол бичгийн судалгаа, сурталчилгааг өргөжүүлэх, Уйгаржин бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, сурталчлан таниулах зорилгоор 10 дахь жилдээ зохион байгуулж буй юм.

Уралдааныг энэ жил алдаагүй зөв бичих, таталган бичгийг алдаагүй зөв унших, цэвэр сайхан бичих, уран бичлэг гэсэн 4 төрлөөр явуулж байгаа бөгөөд өнөөдөр алдаагүй зөв бичих, таталган бичгийг алдаагүй зөв унших төрөлд 60 гаруй оролцогч өрсөлдлөө. Маргааш дараагийн 2 төрлөөр уралдааныг явуулж нэгдсэн дүнг гаргана.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 41	☁️ 29

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,469	3,472
EUR 🇪🇺	3,815	3,830
CNY 🇨🇳	501	503
RUB 🇷🇺	42.50	43.50
JPY 🇯🇵	26.60	27.00
KRW 🇰🇷	2.68	2.71

### ЗУРХАЙ



2023.05.03 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 20

**ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР**  
**НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР**

**Үс засуулбал:**  
**ЖАРГАЛ ИРНЭ**  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
**05.32-20.07**  
**Барилдлага:**  
Үл зохицдог  
**Шүтэн барилдлага:**  
Хүрэлцэхүй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. / муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

## ЭМНЭЛГИЙН ТАТАН ГАРГАЛТЫН НИСЛЭГ ҮЙЛДЛЭЭ



Монгол Улсын гавьяат нисгэгч хурандаа Н.Баясгалангаар ахлуулсан Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нислэгийн баг "МИ-171Е" загварын нисдэг тэргээр Улаанбаатараас Дорнод аймгийн Чулуунхороот сумын чиглэлд эмнэлгийн яаралтай

тусламж үзүүлэх нислэг үйлдэж тус суманд тархсан хээрийн түймэрт өртсөн иргэдийн амь насыг аварлаа.

Монгол Улсын дөрвөн зүг найман зовхист байгалийн гамшигт үзэгдэл, гэнэтийн болон

давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын харьяа бие бүрэлдэхүүн хүн ардаа авран хамгаалах нислэгийг тогтмол амжилттай үйлдэж хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэсээр байна.

## ХУРАНДАА Н.НЯМЖАРГАЛ НҮБ-ЫГ ТӨЛӨӨЛЖ ХУРАЛД ОРОЛЦОЖ БАЙНА



Ази-Номхон далайн бүс орнуудын Энхийг сахиулах ажиллагааны сургалтын төвүүдийн холбооны дарга нарын цугларалт 12 дахь удаагаа Австрали Улсын Сидней хотод 5 дугаар сарын 1-ний өдрөөс 5-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байна.

Бүс нутагтаа төдийгүй дэлхийд нөлөөллөөрөө

дээгүүрт бичигддэг энэхүү холбооны хурал 2011 оноос хойш тасралтгүй явагдаж байгаа бөгөөд энэ жил "Дэлхийн энх тайвны төлөө хамтдаа зүтгэе, хамтдаа хүчтэй" уриатайгаар Австрали Улсад анх удаа зохион байгуулагдаж байна.

Хуралд Монгол Улс, Австрали, Бангладеш, Бруней, Камбож, Канад, БНХАУ, Индонез, Япон, Малайз, Балбын Вант Улс, Шинэ Зеланд, Филиппин, БНСУ, Зүүн Тимор, Тонга, Тайланд, Вьетнам зэрэг орны 22 орны Зэвсэгт хүчний Энхийг сахиулах ажиллагааны сургалтын төвийн дарга нар болон ахлах багш нарын төлөөлөл оролцож, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны бодлогын баримт бичигт тулгуурлан цэргийн баг, алба хаагчдыг сургалтын стандартын дагуу бэлтгэх, үүргээ амжилттай гүйцэтгэх, сургалтын төвүүд мэдээллээ байнга солилцдог байх талаар харилцан ярилцаж байгаа юм.

Тус хуралд Монгол Улсын Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Захирагчийн орлогч, Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн дарга, дэд хурандаа Н.Гантулга, тус төвийн Олон улсын сургалтын бүлгийн багш, хошууч А.Дөлгөөн нар оролцож байна. Энэ удаагийн хуралд оролцогчдод

мэдээлэл хүргэх үүднээс НҮБ-ын холбогдох бүрэлдэхүүнийг урилгаар оролцуулж байгаагийн дотор НҮБ-ын Энхийн ажиллагааны газрын Нэгдсэн сургалтын албаны гишүүн улсуудад дэмжлэг үзүүлэх хэлтсийн дарга хурандаа Н.Нямжаргал, НҮБ-ын Цэргийн хүч бүрдүүлэх стратеги төлөвлөлтийн ажилтан хурандаа Иво Вернеск, "Дэлхийн энхийг санаачилга" хөтөлбөрийн ажилтан Стивен Такоши, Жонатан Свойер нар багтжээ. Тэд төлөөлөгчдөд цаашид энхийг сахиулах ажиллагаанд өндөр түвшинд сургаж бэлтгэгдсэн, орчин үеийн техникээр төхөөрөмжлөгдсөн цэргийн баг болоод алба хаагчдыг илгээхэд хэрхэн анхаарах тухай мэдээлэл хүргэсэн байна.

Ташрамд дурдахад, энэхүү хурлыг Монгол Улсын Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төв 2013 онд эх орондоо зохион байгуулж байсан билээ. Энэ удаагийн хурал НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа эхэлснээс хойшх 75 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буйгаараа онцлог бөгөөд тэмдэглэлт жилийг НҮБ-аас "Энхтайван надаас эхэлнэ" уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлж байгаа ажээ.

Ахмад Д.БОЛОП

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 687,730,631

Эдгэрсэн

Нийт: 658,211,788

Нас барсан

Нийт: 6,859,929

Цахим шууданд

ЧӨЛӨӨНД БАЙГАА ХУРАНДАА С.САЙНЦОГ, Б.ЦЭДЭВ НАРЫН АЛДРЫГ ТЭМДЭГЛЭНЭ



Зэвсэгт хүчний Улсын Үйлчилгээний гавьяат Барилга-инженерийн цэргийн ажилтан, УБХТН-ийн дарга, Ахмадын хорооноос Монгол Сансрын багийн гишүүн асан

чөлөөнд байгаа хурандаа С.Сайнцог, Барилгын цэргийн Ерөнхий газрын Ар тал, эдийн засаг хариуцсан орлогч даргаар ажиллаж байсан хурандаа Б.Цэдэв нарын хөдөлмөрийн алдрыг тэмдэглэхээр төлөвлөжээ.

Монгол Улс, түүний дотор Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин, Барилгын цэргийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан энэ хоёр эрхмийн ажил, амьдралыг сурталчилсан хөрөг нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэх, "Соёмбо" болон "Улаан одхон" сониноор сурталчлах, дурсамж уулзалтууд, нэрэмжит спортын тэмцээнийг зохион байгуулах чиглэлээр ажлын хэсгийн хуралдаан болж, нэгдсэн ойлголтод хүрлээ.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

НИСЭХ ХҮЧНИЙ ТҮҮЧЭЭ БОЛСОН ЗАЛУУ ОФИЦЕР



Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нисдэг тэрэгний хэсгийн борттехникч ахлах дэслэгч Эрдэнэбаатарын Будрагчаа нь анхны бие даасан нислэгээ МИ-171Е загварын нисдэг тэргэн дээр амжилттай гүйцэтгэж борттехникчээр бие даан нисэх эрхээ амжилттай авч нисэх хүчний шинэ залуу боловсон хүчнүүдийн бахархал бахдам амжилтын эзэн нь боллоо.

Ахлах дэслэгч Э.Будрагчаа нь 2013-2019 оны хооронд ОХУ-ын Воронеж хотод Жуковскийн нэрэмжит Агаарын цэргийн академийг МИ-8МТ нисдэг тэрэгний их бие хөдөлгүүрийн инженер мэргэжлээр төгсөж, 2019 оноос хойш тус ангид нисдэг тэрэгний их бие хөдөлгүүрийн техникч,

борттехникчээр ажиллаж байна. Нисэх хүчний шинэ залуу боловсон хүчнүүдийн нэг болох ахлах дэслэгч Э.Будрагчаа нь газрын бэлтгэлийн дадлагыг амжилттай хангаж, 81 цагийн дадлага нислэгийг борт-инженер хошууч С.Энх-Амгалангийн удирдлага дор хийж гүйцэтгэн анхны бие даасан нислэгээ амжилттай гүйцэтгэсэн юм.

Түүний энэхүү баярт үйл явдалд ангийн удирдлага, хамт олон, ар гэрийн төлөөлөл нь оролцож түүнд баяр хүргэн амжилт хүсэж, мөнх хөх тэнгэр нь цэлмэг хөөрөлт буултын тоо нь тэнцүү байхын ерөөлийг дэвшүүлж, ажилд нь амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөв.

БЯЦХАН ХҮҮХДҮҮД ААВ, ЭЭЖИЙНХЭЭ АЖИЛТАЙ ТАНИЛЦАВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд өнөөдөр Төв аймгийн Зуунмод сумын "Унагалдайн андууд" цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүд зочилж, цэргийн ах, эгч нарынхаа ажлын орчинтой танилцлаа. Энэхүү бүлэгт командлалын алба хаагчдын хүүхдүүд суралцдаг учраас эцэг эхийнх нь ажил албыг багачуудад ойлгуулах, нийгмийн хариуцлагын

хүрээнд эргэх холбоотой байж дэмжлэг үзүүлэх зорилгын үүднээс "Аав, ээжийн ажил" өдөрлөгийг зохион байгуулсан юм.

Хүүхдүүд бүлгийн багш Д.Лхагвацэнд болон цэргийн аав, ээжийнхээ заавраар командлалын хурлын танхим, хүндэтгэлийн танхим, музейтэй танилцсанаас хамгийн сонирхол татсан нь музейд тавигдсан байлдааны хэрэгслийн үзвэр байв.

"Жинхэнэ буу мөн үү. Миний аав энэ бууны хажууд зогссон зураг байдаг" гэдэгчлэн нэгэндээ сонин болгон өгүүлж, "Зургаа авахуулж болох уу" гэгцгээх нь өхөөрдөм ажээ.

Ирэх намраас сургуульд суралцах бяцхан хүүхдүүдийн бүлгийн багш нар "Төв аймагт төрлийн цэргийн ийм том командлал шилжин байрласанд баяртай байдаг. Цэргийн байгууллагаар хүүхдүүдээ оруулна гэдэг нь цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг багаас нь суулгах гэсэн том зорилго. Хүүхдүүдийг маань ажил албатай гэж цааргалахгүйгээр элгэмсэг дотноор угтан авсанд баярлалаа" гэсэн юм.



АЛБА ХААГЧДАА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭГТ ХАМРУУЛЛАА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал болон Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн бие бүрэлдэхүүн Монгол Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт 5 дугаар сарын 1-3-ны өдрүүдэд бүрэн хамрагдлаа.

Цэргийн төв эмнэлгийн Поликлиникийн Нүүр ам судлалын тасгийн эрхлэгч, хошууч Н.Очбаяраар ахлуулсан 10 гаруй мэргэжлийн эмч нар үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулж, алба хаагч бүрт эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээг хүргэж ажилласан юм.

Энэхүү урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах

байгууллагын алба хаагчдын дунд явагдаж буй ёс зүй, бие бялдрын бэлтгэжилтийн үзлэгтэй уялдуулан зохион байгуулсан бөгөөд хамрагдсан бүрэлдэхүүний эрүүл мэндийн зэрэглэлээр дүгнэлт гаргах юм.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Цэргийн төв эмнэлгийн Хөдөлгөөнт явуулын амбулатори нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үйлчилгээг 2022 онд эх орныхоо өнцөг булан бүрт хүргэж, Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид, тэний гэр бүлийн гишүүд, цэргийн тэтгэвэр чөлөөндөө гарсан ахмад дайчдаас гадна нутгийн иргэдэд тусламж, үйлчилгээг үзүүлээд байна.

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

ТУУХАЙ ӨРГӨЛТИЙН ДЭЛХИЙН ХОШОЙ АВАРГА Э.БУДЖАВ ДАХИН ТЭРГҮҮЛЭЭ



Туухай өргөлтийн дэлхийн хошой аварга дэд ахлагч Э.Буджав 5 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд ОХУ-д зохион байгуулагдсан "Олон улсын цагаан шөнө" тэмцээнд тэргүүн байр эзэлж, эх орныхоо Төрийн далбааг мандуулжээ.

Тэрээр ОХУ-ын Кострома хотод Цацраг, хими, биологийн зэвсгээс хамгаалах

цэргийн академид суралцдаг бөгөөд 2022 онд БНЭУ-ын Шинэ Дели хотод зохион байгуулагдсан Туухай өргөлтийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний 68 кг-ын жинд түлхэлттэй болон огцом өргөлтийн төрлөөр хос алтан медаль, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс хос мөнгөн медаль, "Олон улсын цагаан шөнө" тэмцээнээс алтан медалийг тус тус хүртэж байсан юм.

Ингэснээр 2022, 2023 онуудад дараалан "Олон улсын цагаан шөнө" тэмцээний аваргаар тодорлоо.

2023 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГАД ТЭНЦСЭН ЗАЛУУЧУУД ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАА ХААХААР МОРДЛОО



Өнөөдөр 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар цэргийн албанд тэнцэн, Зэвсэгт хүчний Жанжин штабын хяналтын тооны дагуу хуваарилагдсан цэргүүдийг цэргийн албанд үдэн мордууллаа. Тус үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёл, Цэргийн штабын дарга хурандаа

О.Ганзориг, Хилийн цэргийн 0146 дугаар ангийн захирагч хурандаа О.Азхүү, 12 сумын Засаг даргын газрын дарга нар оролцож цэргийн албанд тэнцэн, эх орноо хамгаалахаар явж буй залуустаа амжилт хүссэн юм.

Цэргийн алба хаана гэдэг нь цэргийн хэргийн эрдэм, мэдлэгээс гадна амьдралдаа хэрэгтэй зан төлөв, тэсвэр хатуужил, цаг төлөвлөлт, итгэл үнэмшил, бахархал омогшил гээд олон ч зүйлийг сурч мэддэг билээ.

Ийнхүү ар гэр, ах дүүс, найз нөхөд, ард түмнийхээ халуун итгэл хайраар үдүүлэн энх цагийн манаанд эх орондоо үүрэг гүйцэтгэхээр мордож буй Дорнод аймгийн эрхэм залуучууддаа Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн журамт үүрэг нэр төртэй биелүүлэхийг хүсэн ерөөв.

ДОРНОД АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

ХААН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАНИЛЦУУЛЛАА



ЗХЖШ-ын мэдээллийн цагаар ХААН банкны харилцааны менежер Г.Содонцэцэг, Т.Солонго, Б.Урангуа нар тус банкны үйл ажиллагаа, онлайн зээл, цахим бүтээгдэхүүнийхээ талаар бие бие бүрэлдэхүүнд танилцуулга хийлээ.

